



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/247

Ховд

Санхүүжилт шилжүүлэх тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор хог хаягдлын үйлчилгээний хураамжийг чөлөөлсөний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн санхүүжилт болох 27 549 045 төгрөгийг сумдад хувиарлан, хавсралтаар батлан шилжүүлсүгэй.

2. Дээрх санхүүжилтийн 27 549 045 төгрөг /хорин долоон сая таван зуун дөчин есөн мянга дөчин тав/-ийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн санхүүжилтээс санхүүжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Хог хаягдлын хураамжийн чөлөөлсөн санхүүжилтийг зохих журмын дагуу зарцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 25-ны өдрийн
А/247 дугаар захирамжийн хавсралт

Сумдад олгох хог хаягдлын үйлчилгээний хураамжийн
дэмжлэг олгох жагсаалт

Сумдын нэр	12 сар	1 сар	2 сар	Нийт
Алтай	326,600	26,491	25,832	378,923
Булган	4,260,000	345,536	336,933	4,942,469
Буянт	1,015,000	82,328	80,279	1,177,607
Дарви	204,300	16,571	16,159	237,030
Дуут	25,000	2,028	1,977	29,005
Зэрэг	323,500	26,240	25,586	375,326
Манхан	642,000	52,074	50,777	744,851
Дөргөн	191,000	15,492	15,107	221,599
Мянгад	112,000	9,085	8,858	129,943
Мөнххайрхан	384,000	31,147	30,371	445,518
Үенч	215,000	17,439	17,005	249,444
Ховд	284,000	23,036	22,462	329,498
Чандмань	34,000	2,758	2,689	39,447
Эрдэнэбүрэн	346,130	28,075	27,376	401,581
Жаргалант	13,503,070	1,095,258	1,067,988	15,666,316
Мөст	454,400	36,857	35,940	527,197
Цэцэг	1,425,000	115,584	112,706	1,653,291
Нийт	23,745,000	1,926,000	1,878,045	27,549,045

-oOo-